



## **"МУЗЕЙН ҮЗМЭР, ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛИЙН ЕРӨНХИЙ БҮРТГЭЛИЙН ПРОГРАМ" (REGISTER)-Д ОРУУЛСАН МЭДЭЭЛЛИЙГ УЛСЫН ТООЛЛОГЫН ТӨВ КОМИССТ ИРҮҮЛЭХ ТУХАЙ**

### **НЭГ. БҮРДЭЛ ХЭСГҮҮД**

#### ***1.1 Register програмд оруулсан мэдээллийн бааз (Database)***

#### ***1.2 Register програмд оруулсан үзмэрийн зургууд***

#### ***1.3 Register програмд оруулсан мэдээллийг хэвлэн гаргаж баталгаажуулсан дэвтэр***

### **ХОЁР. ФАЙЛ**

#### ***2.1 Register програмд оруулсан мэдээллийн бааз (Database)***

Register програмын мэдээллийн бааз D дискний RegisterData фолдер доторх Data фолдерд байрлах бөгөөд MainData.mdf, MainData\_log.ldf гэсэн хоёр файлаас бүрдэнэ. Энэхүү хоёр файлыг, эсвэл энэ хоёр файлыг агуулсан Data фолдерийг Флаш диск, CD/DVD эсвэл зөөврийн харданд найдвартай хуулж ирүүлж болно. *(Register програм нээлттэй үед мэдээллийн бааз хуулагдахгүй алдаа заана. Ийм үед нээлттэй байгаа register програмыг хааж хуулах үйлдэлээ үргэлжлүүлнэ.)*

#### ***2.2 Register програмд оруулсан үзмэрийн зургууд***

Register програмд оруулсан үзмэрийн зургууд D дискний RegisterData фолдерд байрлах бөгөөд энэхүү фолдерийг Флаш диск, DVD эсвэл зөөврийн харданд найдвартай хуулж ирүүлж болно. DVD-д бичиж ирүүлэхээр бол эхлээд RegisterData фолдерийн хэмжээг үзнэ. Хэрэв 4GB-аас их буюу олон DVD-д бичихээр бол Winrar програм ашиглан хуваан архивлаж, хуваасан архивын файл тус бүрийг DVD-д бичнэ. *Winrar програм ашиглан хуваан архивлах тухай дэлгэрэнгүй зааврыг Хавсралт №1-ээс үзнэ үү/*

#### ***2.3 Register програмд оруулсан мэдээллийг хэвлэн гаргаж баталгаажуулсан дэвтэр***

Register програмын Хэвлэх (Excel-рүү гаргах) командыг ашиглан Excel програмуу оруулсан бүртгэлийг хэвлэн гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулсан дэвтрийн эх хувийг ирүүлнэ.



### Winrar програм ашиглан файлыг хуваан архивлах

Энгийн DVD-д бичиж болох дээд хэмжээ 4.7GB байдаг. Гэхдээ мэдээллийн аюулгүй байдлыг бодолцож нэг DVD-д 4.0GB хэмжээтэй файл бичих нь илүү тохиромжтой байдаг. Тиймээс D дискний RegisterData фолдерийг DVD-д бичихийн өмнө тус бүр нь 4.0GB хэмжээтэй байхаар хуваан архивлах шаардлагатай.

1. Таны компьютерт Winrar програм суугаагүй бол [www.monheritage.mn/download/winrar.exe](http://www.monheritage.mn/download/winrar.exe) линкээс татаж авч суулгана.
2. Start цэснээс Winrar програмыг сонгоно.
3. Гарч ирэх цонхоны файлын зам /FilePath/ хэсгээс D дискийг сонгоод RegisterData фолдерийг ивэвхжүүлээд командын мөрнөөс Add командыг сонгоно.
4. Гарч ирэх цонхны **Split to volumes, bytes** хэсэгт 4000000000 /4 тэрбум буюу дөрвийн ард есөн тэг/ бичээд ОК товчийг дарна.
5. Register програмд оруулсан үзмэрийн зургийн тооноос буюу RegisterData фолдерийн хэмжээнээс шалтгаалж хэд хэдэн хэсэг, тус бүр нь 4GB хэмжээтэй архивын файл үүсэх бөгөөд архивын файл тус бүрийг DVD-д бичиж ирүүлнэ.

